



НИЙСЛЭЛИЙН АГААРЫН ЧАНАРЫН  
АЛБАНЫ ДАРГЫН ТУШААЛ

2010 оны 04 сарын 12 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

АЖИЛТАЙ ТАНИЛЦАХ ТУХАЙ

Нийслэлийн Засаг даргын 2009 оны 305, 309 тоот захирамжууд, 2009 оны Үнэлгээний хорооны 2009 оны 11 дүгээр сарын 27 -ны өдрийн 10 тоот зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд автотээврийн хэрэгслээс гарах бохирдлыг бууруулах зорилгоор "Автотээврийн хэрэгсэлд шингэрүүлсэн нефтийн хийн төхөөрөмж суурилуулах" ажлын явц, 2009 оны АБ 09/10 дугаартай гэрээний хэрэгжилттэй танилцах ажлын хэсгийг Албаны дэд даргаар ахлуулан доорх бүрэлдэхүүнтэйгээр томилон ажилуулсугай.

З.Сэргэлэн / Нягтлан бодогч/

О. Алтангэрэл / Автотээврийн бохирдол хариуцсан мэргэжилтэн /

Б. Баясгалан / Хий, шингэрүүлсэн хийн технологи хариуцсан мэргэжилтэн /

Хоёр. "ББНА" ХХК компанийн ажлын явцтай газар дээр нь очиж үзэж танилцан, дүгнэлт гаргаж 2010 оны 04 дүгээр сарын 20 -ны дотор багтаан эргэж танилцуулахыг албаны дэд дарга /Ч.Батсайхан /-д даалгасугай.

ДАРГА



Д. МӨНХЦОГ